

СЭТГҮҮЛЧ Ш.ЦЭРЭНПИЛИЙН НИЙТЛЭЛИЙН УР ЧАДВАРЫН
ЗАРИМ АСУУДАЛД

Б.Хажидмаа*

*МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: шилжилтийн үеийн сэтгүүл зүйн онцлог, Ш.Цэрэнпил, нийтлэл, уран сайхны бичлэгийн төрөл зүйл, хөрөг

1 990 оноос хойш сэтгүүл зүйн салбарт ур чадвар, хөдөлмөр бүтээлээрээ тодорсон авьяаслаг уран бүтээлч олноор төрсөн. Чөлөөт мэдээллийн орчинд өвөрмөц бөгөөд нөлөө бүхий үг, үзэл санаагаараа цаг үеэ дагуулсан нийтлэлчдийн нэг нь Ш.Цэрэнпил юм. Эдийн засаг, нийтлэлийн бодлого, улс төрийн үзэл бодлын хувьд бүрэн бие даасан, ил тод байдал, олон ургалч үзлийн индэр хэмээн үнэлэгдэх болсон чөлөөт хэвлэл нь нийтлэл нэвтрүүлгийн агуулга, туурвих ур дүй, үзэл бодлын өргөн боломж нээсэн төдийгүй тодорхой нэг бичлэгийн төрөл зүйлээр дагнан, өөрийн сургууль дэг бий болгон хөгжүүлэх эрх чөлөө басхүү үүрэг хариуцлагыг дагуулсан билээ.

Либерал, чөлөөт сэтгүүл зүй хөгжсөн орнуудын судлаачдын дунд хэвлэлийн талаар олон онол үзэл баримтлалын урсгал байдгийн нэг нь, дотоод эрх чөлөөний буюу сэтгүүлч нийтлэлч бүтээн туурвих мэдээллийн хэрэгслээ чөлөөтэй сонгож, үзэл бодлоо ямар ч асуудлаар илэрхийлэх

эрхтэй болохын хамт бусдынхыг хүндэтгэх, хүлцэн тэвчих зарчмаар үнэнд хүрэхийг эрхэмлэх явдал хэмээн үздэгт оршино. Ш.Цэрэнпилийн бүтээл туурвилын өсөлт, хөгжил, ялгарал, бичлэгийн төрөл зүйлээр дагнан мэргэшсэн ур чадварт бие хүн, нийтлэлчийн үзэл бодол, итгэл үнэмшлийн бие даасан оршихуйн үнэ цэний учир шалтгаан оршдог. Энэхүү үзэл баримтлалаараа ч хөрөг бичлэгийн нэрт төлөөлөгч болсон Ш.Цэрэнпилийн нийтлэлүүд, хөргүүдийн ур чадварын онцлогийг тодорхойлохыг хичээлээ. Бүрэн бус ч түүний хамгийн их дадамгай, давтамжтай арга барил, уран бүтээл туурвих технологийг томъёолох болно.

Аливаа нийгэм тэр тусмаа ардчилсан улс орны хэвлэл мэдээллийн хэрэгслийн хамгийн чухал үүрэг бол нийгэмшүүлэх үүрэг. Хөрөг нь гол дүрийг алдаршуулах, онцгой тал буюу боловсрол мэдлэг, итгэл үнэмшил, зан байдал, үзэж өнгөрүүлсэн амьдралын туршлага, удам угсаа гээд хувь улс төрчийн нэр сүрийг (имиж) тухайн нийгэм цаг үеийн сорилт, бэрхшээл, үйл явдал үзэгдлийн шалтгаан мөн чанарыг тодруулах, тайлбарлах үзэл дүгнэлттэй холбон нэгтгэдэг бичлэгийн зүйл. Тиймээс ч улс төрийн

сонгуульд нэр дэвшигчийн сонин, сэтгүүл, цахим хуудаснаа түүний талаар хатуу хуурай баримт тоочиж бус харин уран сайхны нийтлэл буюу хөргөөр үзэл бодлын лидер болох, олон нийтийн итгэл сэтгэлийг татах мэдээлэл сурталчилгаагаа хүргэдэг. Ийм хэрэгцээтэй, эрэлттэй бичлэгийн төрөл зүйлээр мэргэшнэ гэдэг бол нийгмийн мэдээллийн чухал орон зайг олж харж, бүтээлчээр хөгжүүлсэн нийтлэлчийн ур чадвар, алсын хараа, мэргэжилдээ үнэнчийн эрэл хайгуул гээд олныг хэлж болно.

Чөлөөт сэтгүүл зүйн эх суурь тавигдсанаас хойш өдгөө хүртэл бодит үнэнийг нээх, эрэн сурвалжлах мэргэжлийн сэтгүүл зүйн төлөвшил, сэтгүүлчийн ур чадварын онцлог, бүтээлд учирч буй саад бэрхшээл, авьяас чадварыг хөгжүүлэх боломжийн талаар шүүмж дүгнэлт хийх ажил үгүйлэгдсээр ирлээ. Чөлөөт сэтгүүл зүйн эхэн үед сонин хэвлэл мэдээллийн багтаамжид илүү анхаарч байснаас, авьяас ур чадвараас илүү дуулиан шуугиант баримт олдог, шуурхай дамжуулдаг чадварыг хөхиүлдэг байлаа. Гэхдээ уншигч сонсогч үзэгчдийн хөгжлийг дагаад хуурай хоосон мэдээлэл биш түүнийг цаг хугацааны өнгөрсөн, одоо, ирээдүйн холбоосонд дүгнэсэн, ул суурьтай үнэлэх, бодитой тайлбартай, басхүү уг дүрс нүдэнд харагдтал дүрслэгдсэн бүтээлийг хүсэх болсны нэгэн бодит гэрч жишээ нь Ш.Цэрэнпилийн хөргүүд олноо сайшаагдсан явдал юм. Үгээр хүнийг, үнэнийг урлах нь чулуугаар биеийг сийлэх адил мэт. Ш.Цэрэнпилийн хөргүүд энгүүн хэллэг, байрыг нь олж шигтгэсэн цэцэн үг, оновчтой адилтгал харьцуулалттай. Үүнийг уран үгийн хойноос хөөдөг гэвэл өрөөсгөл. “Микеланжелогийн Давид уран барим-

лыг харахад залуу эрийн эрүүл бие цогцос, булчин шөрмөс цацардаг бол Ш.Цэрэнпилийн хөргүүдээс баатрын дүр товойн гарч ирдэг (Ч.Чойсамба, 2008) гэж доктор, профессор Ч.Чойсамба хэлжээ.

Ш.Цэрэнпил 1948 онд Төв аймгийн Өнжүүл суманд төржээ. 1968 онд Зуунмод хотын 10 жилийн сургууль төгсөж, 1969-1972 онд Хилийн цэрэгт хугацаат цэргийн алба хаасан. 1972-1980 онд УБТЗ ХНН-д ХЗЭ-ийн анхан шатны хорооны дарга, галын албанд байцаагч, орлогч даргаар ажиллаж байгаад 1980-1984 онд МУИС-ийн Сэтгүүл зүйн ангид суралцан төгссөн мэргэжлийн сэтгүүлч. Тэр бээр, төгсөнгүүтээ 1993 он хүртэл “Үнэн” сонины Сэлэнгэ, Дорноговь аймаг дахь сурвалжлагч, парламентын сурвалжлагч, 1994 оноос “Ардын эрх” сонины улс төрийн тоймч, 1998 оноос “Өдрийн сонин”-ы тоймч, чөлөөт сэтгүүлчээр ажиллажээ. Түүний “Хувь түүх”/1997/, “Дээрхийн гэгээнтэн” /2002/, “Замчдын хөргөөс” /1997/, “Жасрай гуай”, “Таван учраа” /1997/, “Бакула Ренбүүчий” /2001/, “Төрийн сайд Чүлтэмийн Улаан” /1997/, “Маанийн тайлбар сэлт” /1999/, “Хэнээт” /2008/ зэрэг ном хэвлүүлсэн төрөл жанр нь улстөрч, соёл нийгмийн зүтгэлтнүүдийн хөрөг байлаа. Доктор, профессор Л.Норовсүрэн “Ш.Цэрэнпил социалист нийгмийн зогсонги байдал мэдрэгдэж байсан цагт сэтгүүлчийн боловсрол олж, бүтээлч ажлын “гал тогоонд” чанагдах эхлэх үеэсээ өөрчлөн байгуулалтын үзэл санааг хүчтэй мэдэрч, хүлээн авсан нь 1980 оны сүүл хэрд бичсэн нийтлэлүүдээс тодорхой харагддаг (Л.Норовсүрэн, 2002) гэсэн.

Социалист нийгэмд найруулал хэмээх “баримтат дүр бүхий” бичлэг нь

коммунист үзэл суртал, ухуулгын хэрэгсэл болохын хувьд тухайн хүний талаар хэт их магтаал төдийгүй итгэл үнэмшил, сонирхол татахуйц үг утгагүй байсныг чөлөөт мэдээллийн орчинд нийгэм цаг үеийн асуудлыг ончтой, бүрэн зургаар харуулах хөрөг болгон шинэчлэн бүтээсэн нийтлэлч бол Ш.Цэрэнпил мөн.

1. Ш.Цэрэнпилийн баримтаас дүр бүтээх ур чадвар

“Шинжлэх ухаан батлан үзүүлдэг бол сэтгүүл зүй нотлон үзүүлдэг юм” гэж сэтгүүл зүй судлаач Т.Баасансүрэн (Т.Баасансүрэн, 2008) хэлжээ. Нүдэнд харагдаж, сэтгэлд мэдрэгдэж, түүндээ дөрөөлөн төсөөлж, дүрс, үйл явдал үзэгдлийг уншигч бээр харсан мэт санаандаа ургуулан харахуйц үгээр сийлж бичих, сэтгэлийг автуулах нь чухамдаа нотлон бичих чадварын мөн чанар билээ. Ш.Цэрэнпилийн хөргүүд өөрийн эрхгүй инээвхийлэн эсвэл байж ядтал яарч, сэтгэл тогтворгүй болох мэтчилэн шагшиж, шогширч уншигддаг. Тухайлбал, “Хэнээт” хөрөгт “Д.Эрдэмбилэг эрүүлжүүлэхэд баригджээ. Л.Түдэвийн “Хувьсгал тандаа өчье” романыг уншаад цээжин нь жигтэйхэн их гуниг, хорсол хуримтлагдаж, түүнийгээ тайлахаар аяга тагш юм балгажээ. Тэгтэл гай болж нүдэнд нь цагдаа харагдаад орхиж. Д.Эрдэмбилэг “Аа, муусайн ногоон малгайтууд. Та нар юугаа шиншилж яваа юм бэ? Өнөөдөр 1930

он биш шүү” гэж хашгирчээ...” гэх дүрслэл гол дүрийг номд хорхойтой хийгээд номынхоо үйл явдалд шатаж, ноцож ордог хэнээтэй байдлаар дайруулан дотоод ертөнцийнх нь эсрэгцэл тэмцэл, сэтгэлгээний цар хүрээг гаргажээ.

“Хөөдөг хүн” хөрөг эхлэхэд Сэлэнгэ аймагт уран бүтээлийн тайлан тоглолтоор очсон нэрт дуучин, уран бүтээлчид хөөгдөөд Улаанбаатар руу ирээд байгаа баримтаар буюу баатрынхаа талаар юу ч өгүүлэл-

гүйгээр эхэлсэн хэр нь гол дүрийг улам их хүсэмжлэх, эрэн сурвалжлах, өгүүллийн эзэнтэй хурдан очиж танилцах, уулзах эрмэлзэл гойд төрүүлэх найруулга хийжээ. Гол дүртэй холбоотой баримтаар гол дүрийг эрж хайлгаж байж жинхэнэ санаагаа хүргэх дэвсгэр суурь хийх нь мөн л баримтыг гойд ашигласан нэг чадвар.

“Тэр залуудаа дандаа өөрөөсөө царай-

лаг, өөрөөсөө нуруулаг суналзсан, бас ааш байдал аялаг, авьяаслаг хүүхнүүдтэй “үсэрдэг” байсан юм. Үүнд нь бид баахан атаархаж “Энэ атигар хар юм яаж чадаж байна.” гэцгээдэгсэн. Лев Толстой нэгэнтээ “Хүн сайтай эрийг хүүхэн, нохой, нялх хүүхэд гурав анддаггүй юм” гэж А.Чеховт хэлж байсан байдаг” (Ш.Цэрэнпил, “Хэнээт”, 2008) хэмээн Жа.Пүрэв сэтгүүлчийн хөрөгт өгүүлжээ. Хөргийн баатрынхаа талаар мэдээж сайн сэтгүүлч, хөдөлмөрч сэтгүүлч, аливаа



Социалист нийгэмд найруулал хэмээх “баримтаг дүр бүхий” бичлэг нь коммунист үзэл суртал, ухуулгын хэрэгсэл болохын хувьд тухайн хүний талаар хэт их магтаал төдийгүй итгэл үнэмшил, сонирхол татахуйц үг утгагүй байсныг чөлөөт мэдээллийн орчинд нийгэм цаг үеийн асуудлыг ончтой, бүрэн зургаар харуулах хөрөг болгон шинэчлэн бүтээсэн нийтлэлч бол Ш.Цэрэнпил мөн



баримтыг боловсруулж ажилладаг сэтгүүлч, эдийн засгийн сэтгүүлч болох бүх талыг гаргасан. Гэхдээ энэ хэсэгт баатарт маань яаж ийгээд татагддаг охид хүүхнүүдийг гоё сайхан гэснээс биш Жа.Пүрэв сэтгүүлчийг бүр сөргүүлээд "...атигар хар" гэж ирээд бичсэн байтал түүнд бүсгүйчүүдийн хүсэмжит чанар байгааг маш нууцлаг гаргасан гэлтэй. Ийм баримт баргийн хөрөгт орохгүй л болов уу. Мэдээж, улстөрчийн хөрөгт оруулбал бүүр сөрөг нөлөө үзүүлж таарна. Гэтэл сэтгүүлчид элгэмсэг охид бүсгүйчүүдийн талаарх дүрслэлийн хамт Жа.Пүрэвийн цайлган чанга инээдэг эр болохыг хавсруулснаараа үнэхээр "Энэ ер нь ямар эр байна..." гэж сонирхол татагдахаар болжээ. Сайн сэтгүүлч байж болно. Бас сайхан эр хүн гэдэг санааг дээрх дүрслэлээс өөрөөр гаргах арга байхгүй биз. Илүү давж гаргах ч арга юу л бол? Сайхан эр хүний бүрдэл нь зүс царай, биеийн хэмжээ юм уу өндөр ханагар цээж нураанд байдаггүй л юм байна гэх мэт гоо сайхны хэмжүүрийн талаар нягт тооцоотой бичжээ.

2. Ш.Цэрэнпил хөргүүд улс төрийн нийтлэл болох нь

Сэтгүүл зүйн бүтээл уран гоё сайхан бичих, хурдан шуурхай уншигч сонсогчдоо хүрэхийн чухам аль нь чухал вэ гэгдэх асуулт тавигдсаар байдаг. Мэдээж, хөрөг нийтлэлийн хувьд цаг хугацааны хурд шаардахгүй. Гол дүрийн талаар баримтыг сонгох, боловсруулахад цаг хугацаа бүүр ч хамааралгүй. Харин ч урт хугацааны, магадгүй гол дүрийн амьдралын бүх хугацаанаас шүүж авсан баримт, боловсруулалт байж гэмээнэ үнэ цэнтэй болж мэдэх. Өөрөөр хэлбэл, тухайн хөрөг улс төрийн хугацаат сонгуулийн хэвлэ-

мэлд нийтлэгдэх мэт зорилгоор хэрэглэгдэх тохиолдолд л цаг хугацааны шаардлагад орно. Түүнээс өчигдөр газар хөдөлснийг долоо хоногийн дараа мэдээлэхэд ач холбогдолгүй болохтой ижил зүйл биш гэдэг тодорхой. Энэ бол уран сайхны нийтлэл, хөрөг төрөл зүйлийн бас нэг давтагдашгүй онцлог.

Ш.Цэрэнпилийн "Хэнээт"-ийн төгсгөлийн өгүүлбэр "Өнөө жил соёлын жил билээ" гэж дууссанаар хөргөө нэгдүгээрт, тус соёлын жилийн зорилгыг хангах соёлын бүтээл мөн гэж зохиогч өөрөө хөргөө тодорхойлжээ. Мэргэжил, бүтээлдээ бардам байна, тэр. Нэгэн номын хорхойтон "Монголын нууц товчоо" бүтээлийг цээжилсэн мэтээр дүрслэгдэх ч далд санаа нь соёлын жилийн хүрээнд тус бүтээлийг алдаршуулах, хадгалах, хамгаалах, түгээхэд юу хийх ёстой юм бэ гэдгийг нээн асуусан байх юм. Хоёрдугаарт, соёлын жилийн утга учир юунд чиглэж, ямар байх ёстой юм бэ гэдэг асуултыг төр засаг, уншигч сонсогчдод тавьжээ. Гуравдугаарт, Эрдэмбилэг багш мэтчилэн соёлын өвийн тээгч нар байна аа, тэдний нийтлэг дүр ямар вэ гэдэгт хариулжээ. "Энэ багш хүүхдүүдээ багаас нь номд элэгтэй болгож, тэднээрээ "Монголын нууц товчоо"-г олон дахин уншуулж, улмаар тэрхүү дээж судрыг шүтэж, гэрийнхээ хойморт тахих учиртай ном гэж итгүүлсэн байна. Сайн ном хүнд яаж хүрдгийн зөвхөн ганц жишээ хэмээн дээрх баримтыг сийрүүлэв." (Т.Баасансүрэн, 2008) гэснээр Эрдэмбилэг багш төдийгүй түүний аав эх түүхээрээ хэрхэн бахархах, түүнийг хэрхэн уламжлуулан үнэлүүлэх үүргээ чин сайн гүйцэтгэгч мөн соёлын өв хамгаалагч болохыг гаргажээ.

Ш.Цэрэнпилийн хөрөг бүхэн нийгэмд болохгүй байгаа ямар нэг асуудлыг хөндсөн шинжтэй. “Хөөдөг хүн” буюу “Кант Балдан”-г нийгэм ч хэрэглээгүй, өөрөө өөрийгөө ч гүйцэт хэрэглээгүй, хэрэглүүлээгүй гэдэг утга цаанаа нийгмийг хатуу шүүмжилсэн аястай. “Балдан бол ерөөсөө Европ зүгийн ном зохиолд олонтоо дүрслэгддэг шиг тийм нэг орхигдож, гээгдсэн язгууртан, үе дамжсан сэхээтэн юм”, “Түүний дотоод ертөнц хүчирхэг боловч түүнийг нь нийгэм хэрэглэсэнгүй, тэр өөрөө өөрийгөө ч гүйцэт хэрэглэх хувь дутсан мэт санагдана” гэх төгсгөлөөс Европ зүгийн хэмжээнд дүйм удам судар, үнэ цэнэ бидний дунд бий юу, үүнийгээ үнэлдэг үү, хүчирхэг хүмүүсийн нөөцийг бүрэн хэрэглэдэг үү, хэрэглэхийн төлөө нийгэм мөн үү, хувь хүн өөрөө өөрийгөө нээх хүчээ гаргахын төлөө явдаг уу, тэгэх боломж энэ нийгэмд байна уу гэх мэт олон асуултыг сөргүүлэн тавьж байна. “Хэрэв нийгэм тань болохгүй болсон, тэр байтугай хямарч сүйрч байгаа бол тухайн нийгэм конформист аялдан дагалдагчдаас бүрдэж байжээ гэсэн үг” гэж сэтгүүлч Ч.Эрдэнэ хэлсэн байдаг. Тэгэхээр “Хөөдөг хүн” бол конформист буюу нийгмийнхээ учир зүйг танихгүй хөөн өнхөрч, аялдан дагахыг үл тэвчигч хүн “Кант Балдан”-г цаг үе хэрэвзээ хэрэглэсэн бол хойч ирээдүй, хөгжил дэвшил, тэдний үзэл санаанд хэрхэн шинэчлэл хийх үр болох бол гэдэг гашуудал төрүүлж буйгаараа Ш.Цэрэнпилийн бүтээлүүд ач холбогдолтой, улс төртэй. Энэ бол нийгэм хойч үеийнхээ төлөө ташуур барихгүйгээр хаягдаж мартагдсан нөхцөл байдал, санаа эсвэл бүр мэддэг хэр нь бидний мэдээгүй мэт орхиод явдаг онгойлгоогүй цоо шинэ хаалганы ард

“Кант Балдан” шиг хэн, хэдий олон байгааг асуусан, сануулсан хурц шүүмжлэл. “Кант Балдан” бол ямар ч байсан хаягдсан юм байна. Түүн шиг нь тэр үед ч, одоо ч хэд байгааг мэдэхгүй, мэдэхийг ч эс болон зорилтот тогтсон хэм хэмжээсээрээ хүсэхгүй нэг л их яарсан даарсан, халамж зулгуйдаа автсан нийгэм л өнөөдөр ч нүүгэлтсээр байна. Өнөөдрийг, 2023 оны ийм цаг үеийг мэдсэн, харах юм шиг, харсан юм шиг бичсэнээрээ эл хөрөг бүтээл мөн.

“Их эд” хөрөгт “МАХН-ын /одоогийн МАН/ ганц чаддаг юм нь боловсон хүчиндээ хариуцлага тооцдогт байсан гэдэг. Гэтэл түүнийгээ огт чадахаа байжээ гэж Бямбадорж бачимдан цангинуулдаг. МАХН даргатай байх ёстой. Энэ чухал албыг Ерөнхий сайд хавсран гүйцэтгэвэл намын дотор сахилга бат тогтож, эв нэгдэл илүү хангагдана гэж тэр үзэж байна. Намын дарга биш Ерөнхий сайд улс төрийн нөлөөлөл багатай байгааг энэ эрхэм гишүүн олон баримтаар нотолдог. Сөрөг намууд хэтэрхий удаан өсөж өндийж байна. Энэ нь нийгэмд хортой юм. Манайд 2-3 хүчирхэг нам бие биеэ хянан зогсож байж ардчиллын эрх ашиг хангагдана. Зарим намын удирдагчийн хүчин мөхөс байдал намдаа нөлөөлж, нам нь удирагчийнхаа өмнөөс золиос болж байна гэж энэ эрхэм гишүүн хэлж байсан” (Ш.Цэрэнпил, 1995) гэсэн улс төрийн лидерийн санааг яриа, хандлага дундаас нь судалж таньж явахдаа тэр олж, түүндээ тогтож бичсэн байна. Эсвэл гол дүр маань “Миний энэ санааг тодотгоод гаргаарай...” гэж захисан ч байж болно. Гэтэл тэртээ 1995 онд улстөрч ч яах вэ ярьж л байдаг юм байж түүнийг бичсэн

сэтгүүлчийн улс төрийн энэ сэдвийн биелэл өнөөдөр үнэхээр энэ цаг үеийн, “улс төрийн ертөнцийн шүдний өвчин” болжээ. Намын дарга гэдэг улс төрийн сонгуультанд Ерөнхий сайдын их эрх мэдлийн төвлөрөл зөв үү, буруу юу? Өдгөө юун 2-3 хүчирхэг нам биеэ хянах, өрсөлдөх, хөгжлийн загварууд уралдуулах улам бүр хагарч бутарсан бус уу? Улам бүр нэг намын “хаанчлалд” орж, өрсөлдөгч хянагч байх найдвар болсон ганц нам нь мөнхийн тамга тэмдгийн хэрүүл, даргаа ч сонгож чадахгүйд хүртлээ сульданд, сэхээнд оржээ. Өөрөөр хэлбэл, тэртээ 28 жилийн өмнө яригдаж байсан улс төрийн асуудал өнөөдөр ч шийдэгдээгүй, эсвэл шийдэгдсэн нь хүссэн үр дүн авчраагүйн биелэл байсан. Энэ биелэл энэ цаг үеийнхний хүсэмжит дүр зураг мөн үү гээд нэхэл удаантай, хөгжил дэвшлийн үнэхээр зааг байж мэдэх асуудлыг тэр үед л хөнджээ.

Ер нь Ш.Цэрэнпил 1980-аад оны сүүлчээр өөрчлөн байгуулалтыг сэтгүүлчид өөрсдөдөө ч хийхгүй бол урагшлахгүй нь ээ гэсэн санааг илэрхийлсэн нийтлэл бичиж байж. Мөн их зориг, санаачилга шүү. Тэр өдөр шөнөгүй хуралдчихаад тарангуутаа арга барил нь онхи хэвээрээ байна, шинээр сэтгэж, шинээр ажиллаач гэж тухайлсан намын хорооны ажилд тулгуурлан бичсэн нь ч бий. Гэхдээ улс төрийн улайрсан, туйлширсан нийтлэлүүдээс хөндийрч, уран сайхны тэр дундаа хөрөг бичлэгийн төрөл зүйлээр дагнаснаар нийтлэлийн амин сүнс, зорилго агуулга нь улс төрийн том шийдвэр, үзэгдлийг эгэл жирийн жишээ амьдралын өгүүлэмжээр тодотгох гүн утга, үнэний зорилго байжээ. Доктор, профессор Л.Норовсүрэн “Өөрчлөн байгуулалтын үзэл санаа газар авсаар тайван замын

ардчилсан хувьсгалд шилжсэн үеэс нийгмийн оюуны амьдралын хүрээнд эргэлтийнх шинжтэй өөрчлөлт гарч эхэлсэн билээ. Үнэнийг хэлэхэд энэ үеийнх сэтгүүлчдийнх ихэнх нь хуучин шинийн заагт бэдэрч, аргаа олохгүй мунгинаж явсан юм. Яг ийм хямралт байдлын дундаас Ш.Цэрэнпил явууртай бөгөөд өвөрмөц гарцыг олж, өөрийн гэсэн өвөрмөц арга барилаараа тодрон гарсан.” (Л.Норовсүрэн, 2002) хэмээн тодорхойлжээ.

3. Ш.Цэрэнпилийн богино өгүүлбэрээр бичих, гарчиг сонгох ур чадвар

Ш.Цэрэнпилийн ур чадварын өөр нэг чанар бол богино өгүүлбэр, үгийн сонголтыг гарамгай хэрэглэдэг чадвар. Сул үггүй, үг бүхэн том зорилго тээж байдаг. “Хавсарсан нийлмэл өгүүлбэр ховор тааралддаг нь нийтлэлийг эв нийцлээр тэгш, төвөггүй энгийн ойлгомжтой болгодог. “Авьяасын эгч нь богино бичих чадвар” гэж алдарт А.П.Чехов тэмдэглэсэн.” (Ш.Цэрэнпил, “Хэнээт”, 2008) гэж Шинжлэх ухааны доктор, профессор М.Зулькафиль онцолжээ. Гэхдээ ямар нэгэн уран маягтай үг хэллэггүй, онож таарсан үнэн үгийг богино өгүүлбэр болгож бичдэг байна. Бизнесмен эмэгтэй Г.Алтангийн тухай хөрөгт Ш.Цэрэнпил “АПУ-ийн төлөөх тулалдаанд ялагдсан нь Алтанг бүр хяр дээр гаргажээ. “Даравч дардайна, булавч бултайна” гэдэг шиг болсон. Бас “Яс сайт яван чангарна” гэж үг бий.” (Ш.Цэрэнпил, “Хэнээт”, 2008) гэхчлэн өгүүлбэр бүр 7-8 үгтэйгээр бичжээ. Гол дүрээ яасан ч тамираа тавьж өгдөггүй, зорьсондоо хүрдэг амжилттай болохыг нь тодорхойлохын тулд хоёр өгүүлбэр дамжуулан хэлц үг ашиглажээ. “Хэнээт” хэмээх Эрдэмбилэг багшийн хөрөгт “Хүүхдүүд учиргүй боомдож урвайцаав. Авгай ч шатаж

гарчээ. Хэнээтэй амьтан! Хэнээт!” (Ш.Цэрэнпил, "Хэнээт", 2008), “Д.Эрэмбилэгийнхэн аав, ээжээс ар-вуулаа юм. Хамгийн том нь Эрдэмбилэг.” (Ш.Цэрэнпил, "Хэнээт", 2008) гэм мэтээр бичих биш хүнтэй яриад сууж байгаа юм шиг, маш богино, маш тодорхой.

Уншигч, сонсогчдод мэдээллээ, утга санаагаа зовлонгүйгээр, шууд ойлгогдох байдлаар бичих нь нийтлэлийн үр нөлөө, уншварт хамгийн чухал зорилго билээ. Сэтгүүл зүйн салбарт ажиллаж буй хэн бүхэн мэддэг, зорьдог ч түүндээ хүрч чаддаг нь цөөн. Тиймээс Ш.Цэрэнпилийн энэ арга барил ялгарчээ. Нийтлэлч Баабарыг тэр бээр “Тэр яаж ингэж бичиж чадаж байв. Энэ бол осолтой тоглоом. Ингэх нь түүний амь насанд хүрэх биш юм аа гэхэд амьдралыг нь тэнссэн хэрэг байлаа. Ямар хүч түүнийг ингэж “тэнэглэхэд” хүргэсэн нь тодорхойгүй. Энэ тухайгаа одоо ч тайлбарладаггүй. Өнгөрснөөрөө гайхуулах дургүй бололтой.” (Ш.Цэрэнпил, 1996) гэсэн хэсэг зургаан өгүүлбэр. Эхний хоёр, сүүлийн хоёр өгүүлбэр бараг ижилхэн хэмжээ, үг үсэгтэй шахуу. Дунд хоёр өгүүлбэр мөн хэлбэр, хийц маш ижил. Шүлэг найраглал бол толгой холбож, үг үсгийн ижилсэл, хэмжээ тоогоор баригдаж учир замбараатай болдог шиг үргэлжилсэн үгийн бүтээлд ч эмх цэгц, ижилсэл оруулах нь уншигч хүртэхэд хялбар болдог юм байна.

Яг хөрөг доторх богино, тодорхой өгүүлбэр шигээ гарчигт түүнээс ч бүр тод хэр нь агуулгын хувьд хавь ойрд хэрэглэгдээгүй юм шиг, бүр монгол хэлний үгийн санд бас ийм үг байна аа гэхээр үгсийг онож тааруулсан жишээг ярихгүй орхиж боломгүй. “Гэгээрэл дэвшлийн хүрдэн”, “Жич

өгөгдөхүүн”, “Танигдахуй болоод эс танигдахуй”, “Буурал баавгай буцаж ирлээ”, “Элчин багш”, “Сэтгэгч, эс мятрагч”, “Хэнээт”, “Тэнгэрийн хэл”, “Хөөдөг хүн”, “Хачин намтар”, “Их эд”, “Гүүр” гээд Ш.Цэрэнпилийн бүх хөргийг бүгдийг жагсааж ч болно. Уншигчийн мэддэг үг үү, монгол үг үү гэвэл тийм. Гэтэл ийм үг байдгийг мартсан юм байна шүү дээ гэж харамсаж бодтол үгэн шүр, сувд түүж хөрөгтөө оноох нь бүтээлч чанар, бүр нэн хөдөлмөрч чанар. Сэтгүүлч гэдэг үгний үндэс нь сэтгэ гэсэн үг юм шүү гэдэгчлэн сэтгэхийн нэгэн салаа замыг гарчигтаа ашиглаж чаджээ. Түүсэн, олсон шүр сувд гэхээр гоёл чимэглэлийн мэт нэг тийм чамин, ганган үгс бол бас биш. Гаргах гэж буй агуулга, дүрийн талаар баримтаар өрж босгож дуусахад уншигчийн оюунд түүний талаар ийм л уул, харгуй бүрдэх ёстой гэдгээ нарийн тооцоолсныхоо хураангуйгаар гарчигладаг юм байна. Үнэхээр өдөр тутмын сонины нэг нүүр хөргийн бүтэн хураангуй, хамгийн бага илэрхийлэл яг онож болж чаддаг учраас хөрөг бүхний гарчиг сэтгэл татам болжээ. Уншиж дууссаны дараа ч гарчгийг дахин, дахин уншмаар болтол үнэн чухал хэрэглэгдэхүүн нь мөн болохыг баталжээ.

1. Нийтлэлч Ш.Цэрэнпилийн хөрөг нь зохиогчийн ертөнцийг үзэх үзлийн нэг хэлбэр болсон бөгөөд бичлэгийн өвөрмөц арга барил, содон өнгө аяс, давтагдашгүй найруулгаараа Монголын нийтлэлийн өвд хүндтэй байр эзлэх, одоо ч танин мэдэхүй, соён гэгээрүүлэх ач холбогдлоо алдаагүй бүтээл мөн. Уран бүтээлийн дийлэнх хувийг эзлэх, ур чадварын тодорхойлолтод хүргэсэн нэрийн хуудас хөргүүдийнхээ гол дүртэй холбоотой баримтаар баатрыг эрж хайлгаж

байж жинхэнэ санаагаа хүргэх дэвсгэр суурь хийхдээ амьдрал, үйлс, түүхийн талаар баримтыг гойд ашиглаж даджээ.

2. 1984 онд МУИС-ийн сэтгүүл зүйн ангийг төгссөн Ш.Цэрэнпил 80-аад оны сүүлч гэхэд улс төрийн эгзэгтэй асуудлуудаар дайчин, бүтээлч нийтлэлүүд бичиж тогтсон байсан. Доктор, профессор Л.Норовсүрэн “Өөрчлөн байгуулалтын үеийн сэтгүүлчдийн ихэнх нь хуучин шинийн заагт бэдэрч, арга олохгүй мунгинаж байхад Ш.Цэрэнпил өвөрмөц гарц олж, өөрийн арга барилаараа тодрон гарсан” гэж тодорхойлсон. “Үнэн” сонины редакцад эрх баригч намын ажлын арга барил, явц байдал шинэ цагийн өнгө аястай алхаа нийлэхгүй байгааг шүүмжлэн бичиж суусан гэдэг мэргэжлийнхээ зорилгыг үнэгүй сул орон зайд орхиогүй улс төрийн сэтгүүлч байжээ. “Өдрийн сонин”-ы тоймч гэдэг бол улс төрийн нийтлэлч гэсэн албан тушаал юм. Хөрөг бичих болсон нь ч улс төрийн нийтлэлчийн ажлын нь үргэлжлэл байлаа.

З. Нийтлэлийн утга санааг уншигчдад зовлонгүйгээр, шууд ойлгогдохоор бичихийг хэн бүхэн мэддэг, зорьдог ч хүрч чаддаг нь цөөн. Бусдын хичээгээд төдийлөн чадахгүй ур чадварыг Ш.Цэрэнпил эзэмшсэн, өөр-төө бүр тогтсон арга барил болгосон байна Шүлэг найраглал бол толгой холбож, үг үсгийн ижилсэл, хэмжээ тоогоор баригдаж учир замбараатай болдог шиг үргэлжилсэн үгийн бүтээлд ч эмх цэгц, ижилсэл оруулан маш богино бичих нь уншигчид амар хялбар хүртээл болжээ. Хөрөг доторх богино өгүүлбэр шигээ, гарчигт түүнээс ч бүр тод хэр нь агуулгын хувьд хавь ойрд хэрэглэгдээгүй юм шиг, бүр монгол хэлний үгийн санд бас ийм үг

байна аа гэхээр үгсийг онож тааруулах чадвартай. Өдөр тутмын сонины нэг нүүр хөргийн бүтэн хураангуй, хамгийн бага илэрхийлэл яг онож болж чаддаг учраас хөрөг бүхний гарчиг сэтгэл татам болжээ. Уншиж дууссаны дараа ч гарчгийг дахин дахин уншмаар болтол үнэн чухал хэрэглэгдэхүүн нь мөн болохыг баталжээ.

Эшлэл

1. Л.Норовсүрэн. (2002). "Монголын сэтгүүлзүйн түүхэн тойм" III боть. Л.Норовсүрэн, "Монголын сэтгүүлзүйн түүхэн тойм" III боть (115). Улаанбаатар: Удам соёл.
2. Т.Баасансүрэн. (2008). Ш.Цэрэнпилийн хөрөг. "Хэнээт", 14.
3. Ч.Чойсамба. (2008). "Хэнээт" ном, 33.
4. Ш.Цэрэнпил. (1995). "Ардын эрх-Өнөөдөр", 225.
5. Ш.Цэрэнпил. (1996). Ардын эрх, 52.
6. Ш.Цэрэнпил. (2008). "Хэнээт". Ш.Цэрэнпил, 6.
7. Ш.Цэрэнпил. (2008). "Хэнээт". Ш.Цэрэнпил, 83.
8. Ш.Цэрэнпил. (2008). "Хэнээт". Ш.Цэрэнпил, 9.
9. Ш.Цэрэнпил. (2008). "Хэнээт". Ш.Цэрэнпил, 12.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Цэрэнпил Ш. (2008) "Хэнээт" ном
2. Зулькафил М. (2009, 2010, 2017, 2018) "Сэтгүүл зүйн судалгааны бүтээлүүд" VI, XVI, XX, X, VIII, XI боть
3. Норовсүрэн Л. (2005) "Монголын сэтгүүл зүйн түүхэн тойм" III боть
4. "Сэтгүүл зүй" сэтгүүл 2021/№22-561/, 2018 /№19-496
5. "Ардын эрх-Өнөөдөр" сонин 1995-11-15. №225
6. "Өдрийн сонин" 2004-01-15, №012

Summary

In the realm of journalism since 1990, a multitude of gifted artists has emerged,

among them Sh. Tserenpil stands out as a publisher who adeptly navigates the evolving times through his distinctive and impactful words and ideas in the realm of free information. The cherished free press, serving as a platform for economic, publishing policy, and political perspectives, stands as a bastion of complete independence, transparency, and pluralism. It not only provides vast opportunities for content, creative skills, and diverse opinions but also imposes the responsibility that accompanies the freedom to shape and cultivate one's unique narrative style.

Sh. Tserenpil's portrait emerges as a manifestation of the author's worldview, representing a work of enduring cognitive and enlightening significance. With its unparalleled recording method, distinctive tone, and unique composition, it secures an esteemed position in the heritage of Mongolian publications, symbolizing a formative contribution to the evolving landscape of journalistic expression.

Keywords: characteristics of transitional journalism, Sh.Tserenpil, artistic genres of journalism, portrait.